



**ДАРХАН ХОТЫН СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН ОНӨААТҮГ
2026 ОНЫ ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ҮЕЭР ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИД ТАЛБАЙ
ТҮРЭЭСЛЭХ ЖУРАМ**

Дархан-Уул аймаг

2026 оны 06 сар 26 өдөр

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь 2026 оны Үндэсний их баяр наадмын үеэр худалдаа, үйлчилгээ эрхлэх иргэн, аж ахуйн нэгжийг бүртгэх, талбай хуваарилах, төлбөр авах, үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Худалдаа, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг зөвхөн энэхүү журмын шаардлагыг бүрэн хангасан иргэн, аж ахуйн нэгжид олгоно.

Хоёр. Бүртгэл

2.1. Худалдаа, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгж нь батлагдсан "Талбай түрээслэх хүсэлт"-ийг үнэн зөв бөглөж бүртгүүлнэ.

2.2. Бүртгэл хийхдээ дараах баримт бичгийг бүрэн бүрдүүлсэн байна.

Иргэн

- Иргэний үнэмлэхийн хуулбар
- Хоол үйлдвэрлэл эрхлэх тохиолдолд Эрүүл мэндийн сайдын "Худалдаа Үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах журам"-ын дагуу аймгийн нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн сэргийлэх үзлэг, шинжилгээнд бүрэн хамрагдсан байх (Эрүүл мэндийн цагаан дэвтэр) 4-өөс доошгүй.
- Холбогдох бусад зөвшөөрөл (шаардлагатай бол)

Аж ахуйн нэгж

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Хоол үйлдвэрлэл эрхлэх тохиолдолд Эрүүл мэндийн сайдын "Худалдаа Үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах журам"-ын дагуу аймгийн нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн сэргийлэх үзлэг, шинжилгээнд бүрэн хамрагдсан байх (Эрүүл мэндийн цагаан дэвтэр) 8-аас доошгүй.
- Холбогдох бусад зөвшөөрөл

2.3. Баримт бичгийн бүрдэл дутуу тохиолдолд бүртгэл хийхгүй.

Гурав. Талбай хуваарилах

3.1. Бүртгэл хийгдсэн, материал бүрдэл бүрэн, төлбөр төлсөн, мэргэжлийн байгууллагуудын шаардлагыг хангасан иргэн, аж ахуйн нэгжүүдийг 2026 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 16:00 цагаас "Залуучууд" театрын дугуй заланд сургалтанд хамруулсаны дараа талбай хуваарилж, мандат олгоно.

3.2. Наадмыг зохион байгуулах комиссоос баталсан байршлын дагуу хуваарилна.

3.3. Олгосон байршлыг дур мэдэн солих, бусдад шилжүүлэхийг хориглоно.

Дөрөв. Түрээсийн төлбөр

4.1. Түрээсийн төлбөрийг Наадмыг зохион байгуулах комиссоос 2026 оны 06 дугаар сарын 23-ны өдөр баталсан үнэ тарифын дагуу төлнө.

Төв талбай /Хөл бөмбөгийн талбай/

№	Үйлчилгээний төрөл	Тоо, ширхэг	Цахилгаан, ус, хогны төлбөр
1	Хуушуурын том асар (Онцгой байршил)	6	1,200,000
2	Хуушуурын том асар	10	750,000
3	Хуушуурын гэр (Онцгой байршил)	10	500,000
4	Хуушуурын гэр	58	300,000
5	Шорлог	12	150,000
6	Хүнсний худалдаа (Тогтой)	30	100,000
7	Хүнсний бус худалдаа, тоглоом, зурагчин	20	60,000

Морь барианы газар

№	Үйлчилгээний төрөл	Тоо, ширхэг	Цахилгаан, ус, хогны төлбөр
1	Хуушуурын гэр	20	300,000
2	Шорлог	14	150,000
3	Хүнсний худалдаа	10	100,000
4	Хүнсний бус худалдаа, тоглоом, зурагчин	10	60,000

4.2. Төлбөрийг дараах дансанд шилжүүлнэ.

Голомт банк

Данс: 610015004305154549

Хүлээн авагч: Дархан хотын соёл амралтын хүрээлэн ОНӨААТҮГ

Гүйлгээний утга: Байршлын дугаар – Иргэн/ААН-ийн нэр-Утасны дугаар

4.3. Төлбөр төлөгдсөний дараа байгууллагаас:

- Байршлын дугаар
- Түрээсийн мандат
- Бүртгэлийн дугаар олгоно.

4.4. Мандатгүйгээр худалдаа, үйлчилгээ эрхлэхийг хориглоно.

4.5. Түрээсийн төлбөр буцаахгүй байх нөхцөл

4.5.1. Түрээсийн төлбөрийг төлж, байршил болон мандатаа авсан иргэн, аж ахуйн нэгж нь өөрийн хүсэлтээр үйл ажиллагаа эрхлээгүй, хэсэгчлэн ажилласан, хугацаанаас өмнө үйл ажиллагаагаа зогсоосон, эсхүл ашиглаагүй хоногийн төлбөрийг буцаан олгохгүй.

4.5.2. Түрээсийн төлбөр төлөгдөж, байршил баталгаажсан өдрөөс эхлэн тухайн талбайг бусдад дахин олгох боломжгүй тул төлбөрийг бүхэлд нь тооцож, буцаалт хийхгүй.

4.5.3. Цаг агаарын нөхцөл, бороо, салхи, иргэдийн зорчих хөдөлгөөний бууралт, борлуулалтын хэмжээ, орлогын тасалдал зэрэг түрээслэгчийн үйл ажиллагааны эрсдэл нь төлбөр буцаах үндэслэл болохгүй.

4.5.4. Зөвхөн Дархан хотын соёл амралтын хүрээлэн ОНӨААТҮГ-ын шийдвэрээр наадмын арга хэмжээ бүхэлдээ цуцлагдсан, эсхүл тухайн байршил байгууллагын буруугаас ашиглах боломжгүй болсон нь баримтаар тогтоогдсон тохиолдолд төлбөрийн асуудлыг байгууллагын удирдлагын шийдвэрээр тухай бүр шийдвэрлэнэ.

Тав. Эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын шаардлага

5.1 Хүнсний худалдаа

- 5.1.1 Худалдаалах хүнсний бүтээгдэхүүн нь гарал үүсэл тодорхой, хүчинтэй хугацаатай байна.
- 5.1.2 Сав баглаа боодол нь бүрэн бүтэн, бүтээгдэхүүний шошго, үйлдвэрлэсэн болон дуусах хугацаа тодорхой байна.
- 5.1.3 Хүнсний бүтээгдэхүүнийг нарны шууд тусгал, тоос шороо, бохирдлоос хамгаалсан нөхцөлд хадгалж, худалдаална.
- 5.1.4 Түргэн муудах бүтээгдэхүүнийг шаардлагатай температурын горимд хадгална.

5.2. Хоол үйлдвэрлэл

- 5.2.1 Хоол үйлдвэрлэлд ажиллах бүх ажилтан хүчинтэй эрүүл мэндийн цагаан дэвтэртэй байна.
- 5.2.2 Ашиглах мах, махан бүтээгдэхүүн нь гарал үүслийн гэрчилгээ, мал эмнэлгийн лабораторийн шинжилгээний бичигтэй байна.
- 5.2.3 Хүнсний түүхий эдийг зориулалтын нөхцөлд хадгалж, боловсруулна.
- 5.2.4 Ажилтан нь ажлын хувцас, малгай, хормогч, шаардлагатай тохиолдолд амны хаалт, нэг удаагийн бээлий хэрэглэнэ.
- 5.2.5 Гар угаах нөхцөл, цэвэр ус, бохир усны сав, хог хаягдлын савтай байна.
- 5.2.6 Мал эмнэлгийн бичигтэй, шинжилгээнд хамрагдсан махыг хүнсэнд ашиглах
- 5.2.7 Цахилгаан хэрэгсэл, хийн баллон ашиглахдаа аюулгүй байдлыг хангасан байх
- 5.2.8 Цахилгаан хуушуурын тогоо ашиглахгүй байх
- 5.2.9 Гал унтраах хэрэгсэл байршуулах
- 5.2.10 Хурдан муудах бүтээгдэхүүн хэрэглэхгүй байх
- 5.2.11 Хувийн ариун цэвэр сахих, гар угаах халдваргүйжүүлэгч ашиглах
- 5.2.12 Хүнсний аюулгүй байдлыг хангах
- 5.2.13 Бохир, хог хаягдалаа ангилж хаях гэх мэт

5.3. Шорлог худалдаа

- 5.3.1 Ашиглах мах нь гарал үүсэл, мал эмнэлгийн лабораторийн шинжилгээний бичигтэй байна.
- 5.3.2 Махыг зориулалтын хөргүүр, хөргөлтийн нөхцөлд хадгална.

- 5.3.3 Ил гал ашиглахдаа галын аюулгүй ажиллагааны шаардлагыг мөрдөж, гал унтраагууртай байна.
- 5.3.4 Шорлог бэлтгэх ажилтан нь хүчинтэй эрүүл мэндийн цагаан дэвтэртэй байна.
- 5.3.5 Гал унтраах хэрэгсэл байршуулах
- 5.3.6 Хурдан муудах бүтээгдэхүүн хэрэглэхгүй байх
- 5.3.7 Хувийн ариун цэвэр сахих, гар угаах халдваргүйжүүлэгч ашиглах
- 5.3.8 Хүнсний аюулгүй байдлыг хангах
- 5.3.9 Бохир, хог хаягдалаа ангилж хаях гэх мэт
- 5.4. Хүнсний бус худалдаа**
 - 5.4.1 Худалдаалах бараа бүтээгдэхүүн нь хууль тогтоомжоор хориглоогүй байна.
 - 5.4.2 Зөвхөн тогтоосон байршилд үндэсний хувцас, бэлэг дурсгал, малгай, шил, шүхэр тоглоом, зэрэг бүтээгдэхүүн, үйлчилгээг эмх цэгцтэй байршуулж худалдаална.
 - 5.4.3 Худалдааны талбай болон ойр орчны цэвэрлэгээг тогтмол хариуцна.
- 5.5. Бусад худалдаа, үйлчилгээ**
 - 5.5.1 Зурагчин, Face Art, сугалаа, үзвэр үйлчилгээ болон бусад үйлчилгээ эрхлэгч нь олгосон байршилдаа үйл ажиллагаа явуулна.
 - 5.5.2 Үйлчилгээ үзүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангаж, бусдын хөдөлгөөнд саад учруулахгүй байна.
 - 5.5.3 Орчны цэвэрлэгээ, хог хаягдлыг өдөр бүр бүрэн хариуцна.
- 5.6. Нийтлэг шаардлага**
 - 5.6.1 Худалдаа, үйлчилгээ эрхлэгч нь Эрүүл мэндийн газар, Хүнс Хөдөө Аж Ахуйн Газар, Мал эмнэлгийн газар, Стандартчлал хэмжил зүйн газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн байгууллага болон бусад эрх бүхий байгууллагын хууль ёсны шаардлагыг биелүүлнэ.
 - 5.6.2 Эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын шаардлага хангаагүй, эрүүл мэндийн бичиг баримтгүй, гарал үүсэл тодорхойгүй бүтээгдэхүүн худалдаалсан, эсхүл эрх бүхий байгууллагын шаардлагыг зөрчсөн тохиолдолд байгууллага тухайн үйлчилгээний үйл ажиллагааг зогсоож, мандатыг хүчингүй болгож, талбайг чөлөөлөх эрхтэй.

Зургаа. Гал, цахилгааны аюулгүй байдал

- 6.1. Цахилгаан хэрэглэгч нь зөвхөн байгууллагаас зөвшөөрсөн эх үүсвэр ашиглана.
- 6.2. Ил задгай цахилгааны холболт хийхийг хориглоно.
- 6.3. Гал унтраагууртай байна.
- 6.4. Ил гал ашиглах тохиолдолд галын аюулгүй ажиллагааны шаардлагыг мөрдөнө.

Долоо. Худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн үүрэг

- 7.1. Олгосон байршилд үйл ажиллагаа явуулах.
- 7.2. Батлагдсан үнэ мөрдөх.
- 7.3. Орчны 5 метр хүртэлх талбайг цэвэр байлгах.
- 7.4. Хогийг зориулалтын саванд хийх.
- 7.5. Байгууллага болон эрх бүхий байгууллагын хууль ёсны шаардлагыг биелүүлэх.
- 7.6. Хугацаа дуусмагц талбайгаа цэвэрлэн хүлээлгэн өгөх.

Найм. Хориглох зүйл. Дараах үйл ажиллагааг хориглоно.

- 8.1. Байршил дамлан худалдах.
- 8.2. Байршлаа бусдад шилжүүлэх.
- 8.3. Мандатгүй худалдаа хийх.
- 8.4. Эрүүл мэндийн бичиггүй хүн хоол үйлдвэрлэлд ажиллуулах.
- 8.5. Шинжилгээний бичиггүй мах хэрэглэх.
- 8.6. Зөвшөөрөлгүй цахилгаан холбох.
- 8.7. Архидан согтуурах, нийтийн хэв журам зөрчих.

Ес. Хариуцлага

- 9.1. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгжид:
 - сануулах,
 - зөрчлийг арилгуулах,
 - мандатыг хүчингүй болгох,
 - талбайг чөлөөлүүлэх,
 - шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагад шилжүүлэх
 - арга хэмжээг авна.

Арав. Бусад

Энэхүү журамд тусгаагүй асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон "Дархан хотын соёл амралтын хүрээлэн"ОНӨААТҮГ-ын шийдвэрээр зохицуулна.